



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/70

Булган

Дэмжлэг үзүүлэх тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Бээжин 2022” өвлийн олимпын наадмын цанын спортын төрөлд Монгол улсаа төлөөлөн оролцож байгаа Булган аймгийн Тэшиг сумын уугуул Олон Улсын хэмжээний мастер А.Энхтуулд 5,500,000 (таван сая таван зуун мянга) төгрөгийн үнэ бүхий цана олгож дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

D/zahiramj/2022

Аймгийн Засаг даргын 2022 оны 02
дугаар сарын 07-ний өдрийн 76 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: -Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: -Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

-А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
дарга)

-Б.Батболд (Мэргэжлийн хяналтын газрын дарга)

-Г.Ганбаатар (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

-Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: -Б.Өнөболд (ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2022 оны 02
дугаар сарын 04-ний өдрийн 769 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШНИЙ ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

1.Зорилго

Аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах газрын байршил, түүхий эдийн нөөц, чанарын судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулахад оршино.

2.Удирдлага болгох хууль тогтоомж

- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай
- Газрын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Холбогдох тогтоол шийдвэр, гэрээ, журам, стандарт

3.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Ажлын хэсэг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдөрт багтаан ажиллах бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1.Сайхан сумын “Эрээн”, Гурванбулаг сумын “Баяндуурах”-ын нүүрсний уурхайд очиж үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцах;
- 3.2.Уурхайн нүүрсийг сайжруулсан түлшний үйлдвэрт түүхий эдээр ашиглах боломжийн талаар судлах. Тухайлбал: Уурхайн эзэмшигчтэй уулзах, нүүрсний нөөц, чанар байдлыг судлах, түлшний үйлдвэрийг түүхий эдээр тасралтгүй хангах талаар зөвшилцөх;
- 3.3.Сайжруулсан түлшний үйлдвэр байгуулах газрын байршлыг тогтоох. Үүнд: цахилгаан эрчим хүч, усны нөөц эх үүсвэр, бусад дэд бүтцийн асуудлыг сайтар харгалзах;
- 3.4.Үйлдвэр байгуулах газар дээр Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй иргэдийн судалгааг гаргах, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;
- 3.5.Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулсан бусад аймаг, хотын туршлагыг судлах;
- 3.6.Түлш, агаарын бохирдлын асуудлаар улсын хэмжээнд баримталж буй бодлого, гадаад улс орнуудын тэргүүн туршлагыг судлах

4.Дүнгийн талаар

Ажлын хэсгийн судалгааны дүн, мэдээллийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Doc/2022/Захирамж